

# ДАВХАР АЖИЛТНЫ КАРТ

# АЖЛЫН БАЙР ЭСВЭЛ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ГАЗАРЫГ ӨӨРЧЛӨХ

Давхар ажилтны карт нь хөдөлмөрийн зах зээлд чөлөөтэй нэвтрэх боломжгүй, 90 хоногоос дээш хугацаагаар оршин суух зөвшөөрөл авах шаардлагатай гадаадын иргэдэд зориулагдсан. Энэ бол ажилд орох зорилгоор удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл юм - тодорхой ажил олгогчтой тодорхой ажлын байр!

**ТАНЫ АЖИЛЛАЖ БАЙГАА АЖИЛ, ЭСВЭЛ АЖИЛ ОЛГОГЧ СОЛИГДСОН ТОХИОЛДОЛ БНЧУ-ЫН ДОТООД ХЭРГИЙН ЯАМАНД МЭДЭЭЛЭХ ХЭРЭГТЭЙ!**

## Ажил олгогчийн ямар өөрчлөлтийг мэдээлэх шаардлагатай вэ?

Хөдөлмөрийн гэрээнд оруулсан бүх өөрчлөлтийг урьдчилан мэдээлэх шаардлагатай, мөн та гарын үсэг зурах хөдөлмөрийн гэрээнд нэмэлт өөрчлөлт орсон зүйлийг хүлээн авах болно. Жишээ нь: ажлын албан тушаал өөрчлөх (ажлын тодорхойлолт), ажлын байрыг өөрчлөх!

- Нэг хотын ажлын байр солигдсон, цалингийн нэмэгдэл эсвэл бусад бага зэргийн өөрчлөлтийн талаар мэдээлэх шаардлагагүй (гэртэй ажиллах, ажил олгогчийн нэрийг өөрчлөх ...). Хэрэв та өөрчлөлтийг мэдээлэх шаардлагатай эсэхийг мэдэхгүй байгаа бол мэдээлсэн нь дээр!

**Ашиглах шаардлагатай маягтыг ажил олгогчийн өөрчлөлт, ажлын ангилал, ижил эсвэл өөр ажил олгогчтой өөр ажилд орсон тухай ажилтны карт эзэмшигчийн мэдэгдэл гэж нэрлэдэг.**

- Дэлгэрэнгүй мэдээлэл болон маягтыг [эндээс авах боломжтой](#).



*Мэдэгдэл гаргах эцсийн хугацаа нь төлөвлөсөн өөрчлөлтийг хийхээс 30-аас доошгүй хоногийн өмнө байна!*

**БНЧУ-ын ДХ яаманд өөрчлөлтийн талаар мэдээлэх нь яагаад чухал вэ? Ажил дээр нь Хөдөлмөрийн хяналтын газраас шалгалт орж ирээд ямар нэгэн дутагдал илэрсэн тохиолдолд хууль бус ажил гэж дүгнэх боломжтой. Таны ажлын карт хүчингүй болж магадгүй.**

## Бодит байдлаас авсан жишээнүүд:

**Таны ажилладаг компани нүүж эсвэл ID дугаараа өөрчилнө.** Аливаа ийм өөрчлөлт нь таны хөдөлмөрийн гэрээнд мөн адил нөлөөлнө. Тиймээс өөрчлөлтийн тухай мэдэгдэл гаргах шаардлагатай.

**Таны ажиллаж байгаа компанийн Усти над Лабем дахь салбарт ажилладаг гэж гэрээндээ бичсэн байдаг. Гэсэн хэдий ч тус компани нь Хомутов хотод салбартай хэвээр байна.** Хэдийгээр энэ нь ижил ажлын байрыг гүйцэтгэх байсан ч анхны гэрээнд заагаагүй бол та Хомутов хотод ажиллаж болохгүй. Хэрэв таныг Хомутов дахь салбар руу шилжүүлэх юм бол өөрчлөлтийн тухай мэдэгдэл өгөх шаардлагатай.

**Компанид та жишээ нь үйлдвэрлэлийн операторын албан тушаалд ажилладаг. "Цэцэрлэгжүүлэлт"-ийн хэлтэст ажилчид дутмаг байгаа тул танай ажил олгогч таныг тийшээ илгээнэ.** Гэхдээ нөхцөл байдлыг ингэж шийдэж болохгүй! Цэцэрлэгжүүлэлт нь таны ажил биш бөгөөд шалгалтын явцад энэ байдлыг хууль бус ажил гэж үнэлэх болно. Таны ажлын карт хүчингүй болж магадгүй.

**АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ ГАЗАР, АЖЛЫН ТОДОРХОЙ ЭРХЛЭХ АЛБАН ТУШААЛ НЬ ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭНИЙ ХЭСЭГ. ӨӨР АЖЛЫН БАЙРАНД ИЛГҮҮЛЖ ӨӨР ҮЙЛ АЖИЛЛАГАА ГҮЙЦЭТГЭЖ БОЛОХГҮЙ. ХУУЛЬ БУС АЖИЛ БОЛЖ БОЛНО. ӨӨР АЖЛЫН БАЙРАНД ШИЛЖҮҮЛЭХ БОЛСОН БОЛ БИЧГЭЭР БАЙХ ЁСТОЙ, ЖИШЭЭ НЬ: ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ ХЭЛБЭРЭЭР. ЭНЭ ӨӨРЧЛӨЛТИЙГ МЭДЭЭЛЭХЭЭ БҮҮ МАРТААРАЙ!**



Spolufinancováno  
Evropskou unií



MINISTERSTVO VNITRA  
ČESKÉ REPUBLIKY



Poradna  
pro integraci

Projekt "Centrum na podporu integrace cizinců v ústeckém kraji" reg. č. CZ.12.01.02/00/23\_008/0000008 je financován OP AMIF a MV ČR.